



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 628

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 585,722,624.48 (төв) таван зуун наян таван сая долоон зуун хорин хоёр мянга зургаан зуун хорин дөрвөн төгрөг дөчин найман мөнгө төгрөгийн балансын үнэ бүхий 541,853,645.81 (төв) таван зуун дөчин нэгэн сая найман зуун тавин гурван мянга зургаан дөчин таван төгрөг наян нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хавсралтад заасан хөрөнгийг Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яамны харьяа байгууллагуудад балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Жамбалцэрэн, Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Баярсайхан, харьяа байгууллагуудын захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001167

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын

2019 оны 8 дугаар сарын 14-д

Балдугаар тогтоолын хавсралт

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын анхны үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Компьютер /Dell/	6/27/2016	ш	1	1,974,057.34	1,974,057.34	1,766,331.12	207,726.22	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн
2	Скайнер /гарын хэмжилт гүйцэтгэх/	6/27/2016	ш	1	55,695,443.92	55,695,443.92	53,584,132.80	2,111,311.12	
3	Скайнер /хөлийн хэмжилт гүйцэтгэх/	6/27/2016	ш	1	59,327,636.38	59,327,636.38	42,068,467.68	17,259,168.70	
4	Дисплей	6/27/2016	ш	1	22,950,927.54	22,950,927.54	18,726,860.12	4,224,067.42	
5	Дэлгэц	6/27/2016	ш	1	416,359.92	416,359.92	267,164.21	149,195.71	
6	Биеийн скайнер /зөөврийн компьютер/	6/27/2016	ш	1	223,506,753.24	223,506,753.24	205,898,409.68	17,608,343.56	
<b>Хэсгийн дүн</b>				<b>6</b>		<b>363,871,178.34</b>	<b>322,311,365.61</b>	<b>41,559,812.73</b>	
1	Үслэг ширхэгийн голч тодорхойлох төхөөрөмж	6/27/2016	ш	1	212,614,830.00	212,614,830.00	212,614,830.00		Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа
2	Дата-сервис	6/27/2016	ш	1	9,236,616.14	9,236,616.14	6,927,450.20	2,309,165.94	Үйлдвэрлэлийн технологийн сургууль
<b>Хэсгийн дүн</b>				<b>8</b>		<b>221,851,446.14</b>	<b>219,542,280.20</b>	<b>2,309,165.94</b>	
<b>НИЙТ ДҮН</b>						<b>585,722,624.48</b>	<b>541,853,645.81</b>	<b>43,868,978.67</b>	
<b>НИЙТ ДҮН</b>						(таван зуун наян таван сая долоон зуун хорин хоёр мянга зургаан зуун хорин дөрвөн төгрөг дөчин найман мөнгө)	(таван зуун дөчин нэгэн сая найман зуун тавин гурван мянга зургаан дөчин таван төгрөг наян нэгэн мөнгө )	(дөчин гурван сая найман зуун жаран найман мянга есөн зуун далан найман төгрөг жаран долоон мөнгө)	